



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 017

Жаргалтхаан сум

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3, 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалт, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай" А/114 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: Л.Мөнхбаяр - Багш

Гишүүд: О.Түвшинбаяр - Нийгмийн ажилтан

Б.Сумъяа - Багш

Г.Урансүх – Нягтлан бодогч

П.Энхбаяр - Жижүүр

2. Зөвлөлийн ажлын чиг үүргийг байгууллагын албан хаагчдад танилцуулах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах, холбогдох хууль, дүрэм, журамд заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга (Л.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Зөвлөл шинэчлэн байгуулах тухай" захирлын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/10 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

С. Оюунцэцэг

С. ОЮУНЦЭЦЭГ



D/Tushaal-2026

232601013